



Монгол Улс

“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” II шат

2020 оны 9 дүгээр сараас эхлэн “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн II шат хэрэгжиж байна. I шатны төслөөр (2015-2019) туршилтын сургуульд хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдэд эрт үеийн хөгжлийн дэмжлэг үзүүлэх, тэгш хамран сургах боловсролыг хөгжүүлэхэд чиглэсэн боловсролын үйлчилгээг сайжруулах зорилго бүхий үйл ажиллагааг зохион байгуулсан.

Энэхүү төслийн II шатанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэг болон боловсролын үйлчилгээг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлнэ. Ердийн сургууль, цэцэрлэгт тэгш хамран сургах боловсролыг хөгжүүлж, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бусад хүүхдүүдийн хамт суралцах загвар боловсруулах ба нийт цэцэрлэгт тус үйл ажиллагааг зохион байгуулна.

- Төсөл хэрэгжүүлэх тогтолцоо -

БШУЯ, Тусгай хэрэгцээт
боловсролын хэлтэс
ХНХЯ
Төслийн баг
Мэргэжил, арга зүйн баг*

Аймаг, дүүргийн тэгш хамран сургах
боловсрол хариуцсан мэргэжилтэн
Аймаг, дүүргийн салбар комиссын
боловсрол хариуцсан мэргэжилтэн**

Үндэсний хэмжээний
цэцэрлэг
Үндэсний хэмжээний
сургууль



- ◇ Сургалт зохион байгуулах
- ◇ Мэдээллээ солилцох тогтолцоо бий болгох
- ◇ Бүх төрлийн гарын авлага боловсруулах

- ◇ Цэцэрлэг, сургуульд зориулсан сургалтууд зохион байгуулах
- ◇ Цэцэрлэг, сургуульд мониторинг хийх
- ◇ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалтыг дэмжих

- ◇ Тэгш хамран сургадаг цэцэрлэг, сургуулийг бий болгох
- ◇ Тэгш хамран сургадаг анги, бүлгийн менежмент

* Монгол Улсад тэгш хамран сургах боловсролын чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдээс (Их дээд сургуулийн багш, Боловсролын хүрээлэнгийн мэргэжилтэн, өмнөх шатны төслийн туршилтын сургуулийн багш нар гэх мэт) бүрдсэн баг.

** Тэгш хамран сургах боловсрол хариуцсан мэргэжилтэн: Аймаг/ Дүүргийн Боловсролын газар/ хэлтсийн тэгш хамран сургах боловсрол хариуцсан мэргэжилтэн.

***Салбар комисс: Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, улмаар хөгжлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 9 дүүрэг, 21 аймагт байгуулагдсан орон тооны бус комисс.



Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Авзага трейд билдинг, 505 тоот



<https://www.facebook.com/JICA.START.2>



<https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/029/index.html>



jicastart2@gmail.com



+976-80486690
+976-95937356



- Төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа -

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГИЙГ ОРОН НУТАГТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Аймаг, дүүргийн салбар комиссын боловсролын асуудал хариуцсан гишүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх дэмжлэгийг судлах “Кейс хэлэлцүүлэг” болон цэцэрлэг, сургуульд орох үеийн “Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал” зохион байгуулж хэвшихэд дэмжлэг үзүүлнэ.



БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Аймаг, дүүргийн тэгш хамран сургах боловсрол хариуцсан мэргэжилтэн нь харьяа цэцэрлэг, сургуулиуддаа тэгш хамран сургах боловсролыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж хэвшихэд дэмжлэг үзүүлнэ.




ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛЬД ХЭРЭГЖҮҮЛЭХ

Үндэсний хэмжээний цэцэрлэг, сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусад хүүхэдтэй хамт сурч боловсрох боломжийг бий болгох үүднээс цэцэрлэг, сургуулиудад “Дэмжлэгийн баг” байгуулах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хүүхэд бүрийн оролцоог хангасан хичээл зохион байгуулахыг дэмжсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.



ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Үндэсний хэмжээний цэцэрлэг, сургуулийн багш нар тэгш хамран сургах боловсролын талаар суралцаж, бодитоор хэрэгжүүлэх чадвар эзэмшихэд чиглэсэн цахим сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулах, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны туршлагаа хуваалцах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.



Япон зөвлөх мэргэжилтнүүд

Сүзүки Саяака: Ерөнхий менежер, тэгш хамран сургах боловсролын бодлого

Иший Тэцүяа: Менежер, тэгш хамран сургах боловсролын бодлого

Исобэ Ёоко, Нишимүра Күмико, Хашимото Сооичи, Ёшино Наоко: Тэгш хамран сургах боловсрол (СӨБ)

Үэхара Шёоко: Тэгш хамран сургах боловсрол (Бага, дунд боловсрол), Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт / Мэдээлэл холбооны технологи

Тажима Кэнжи: Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт / Мэдээлэл холбооны технологи

Накамото Макото: Хяналт мониторинг / Түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэг

Зохицуулагчид

Х.Ганбаатар

Г.Норжмаа

Д.Ариун

Д.Одгэрэл

Ц.Мөнхтуяа

Ц.Энхгэрэл